

ТӨРИЙН ТУСГАЙ БАЙГУУЛЛАГЫН УДИРДАХ АЖИЛТНЫ СУРГАЛТ, ХӨГЖИЛ

“Алба хаагчийн сургалт хөгжлийн асуудал”

Мэдлэгтэй хүн итгэлтэй, итгэлтэй хүн зоригтой. Тийм учраас цагдаагийн алба хаагчид орчин үедээ нийцэж ажиллахын тулд илүү өргөн мэдлэгтэй, өндөр боловсролтой байх хэрэгтэй. Хошууч генерал М.Ганболд

В.ОТГОНБАЯР

Цагдаагийн ерөнхий газрын Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтсийн дарга,
ДХИС-ийн Удирдлагын академийн докторант, цагдаагийн хурандаа

Товч агуулга: Энэхүү илтгэлээр Төрийн албаны тухай хуульд заасан “мэргэшүүлэх багц сургалт”, “богино болон дунд хугацааны сургалт” зохион байгуулах зохицуулалт нь Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад хэрэгжих боломж, сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлохыг зорилгоо.

Үндсэн хэсэг:

Маш хурдтай хувьсан өөрчлөгдөж буй дэлхий нийтийн байдал, улс орны нийгэм, эдийн засаг, шинэ техник технологийн хөгжил нь эрх зүйн шинэтгэл, хууль эрх зүйн харилцааг улам боловсронгуй болгох, эрх зүйн боловсрол мэдлэгийг дээшлүүлэхийг зүй ёсоор шаардсаар байгаа билээ. Энэхүү эрх зүйн шинэтгэлийн хүрээнд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албан хаагчийн боловсрол, мэдлэг, ур чадварын асуудал гарцаагүй хөндөх эрхэм чухал сэдэв мөн.

Монгол Улсын Их Хурлаар 2017 онд батлагдсан “Төрийн албаны тухай хууль”-д:


- Төрийн албаны мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төрийн албаны төв байгууллага, төрийн албан

хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгааг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино гэж,

-Мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалтад “Мэргэшүүлэх багц сургалт”-ын агуулга, хөтөлбөрийг тухайн албан тушаалын онцлог, хариуцсан ажил, гүйцэтгэх чиг үүргийг харгалзан төрийн албаны төв байгууллага, Засгийн газар хамтран батална. Мэргэшүүлэх багц сургалтыг Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага хариуцан зохион байгуулна гэж тусгасан байдаг.




Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 12.0 мянга гаруй алба хаагчдын 60.7 хувь нь бакалавр, 18.1 хувь нь магистр болон докторын зэрэгтэй алба хаагчид байна

МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТ



Цагдаагийн төв байгууллагаас алба хаагчдынхаа мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор гадаад болон дотоодын их дээд сургууль, академид мэргэжил дээшлүүлэх, нарийн мэргэжлээр сургахад тогтмол анхаарч, 2021 онд мэргэшүүлэх 29 удаагийн

сургалтад 3460, ур чадварын 6 удаагийн сургалтад 2092, давтан сургалтад 12 удаа 7591, ажлын байран дахь албаны сургалтыг 4772 удаа 694052 алба хаагчийг давхардсан тоогоор хамруулсан байна¹.



¹Цагдаа, дотоодын цэргийн сургалтын тайлан, мэдээ



Дээрх тоо баримтаас харахад сүүлийн 3 жил буюу 2019-2021 онд давхардсан тоогоор нийт 12332 сургалтад 1,672,771 алба хаагчийг хамруулсан байх бөгөөд энэ нь 1 жилд 4111 удаа, 12 сард 343, календарийн 30 хоногт 11 буюу ажлын 2 хоног тутамд 1 сургалт зохион байгуулсан байх бөгөөд жилд 557590 алба хаагч, сард 46465, өдөрт 1548 алба хаагчийг сургалтад хамруулсан байх бөгөөд өөрөөр хэлбэл нэг алба хаагч 3 жилд 153, нэг жилд 51, сард 4, 7 хоногт тогтмол 1 сургалтад хамрагддаг гэсэн тооцоо гарч байна. Үүнээс харахад сургалтын давтамж, хамрагдаж буй алба хаагчийн тоо **“хангалттай”** хэмжээнд байна гэж үнэлж болохоор байна.

Гэвч Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйл 23.2.1 дэх хэсэгт Тэргүүн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох бол төрийн албанд 12-оос доошгүй жил, үүнээс эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 6-аас доошгүй жил ажилласан байх бөгөөд мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх¹;

Мөн хуулийн 23.2.2 дахь хэсэгт Эрхэлсэн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох бол төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх бөгөөд мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх;

Мөн хуулийн 23.2.3 дахь хэсэгт Ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох бол төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх бөгөөд мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх талаар хуульчилсан бол Цагдаагийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйл “Цагдаагийн албан тушаалд тавигдах шаардлага”, 67 дугаар зүйл “Цагдаагийн албан тушаалд томилох” заалтад “Мэргэшүүлэх багц сургалт”-д хамруулах талаар огт тусгагдаагүй байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоолын холбогдох хавсралтад заагдсан удирдах албан тушаалд цагдаагийн удирдах албан тушаалтныг дүйцүүлсэн ангиллыг хүснэгтээр харуулбал:

№	Төрийн албаны салбар зөвлөлийн 2019 оны 02 дугаар	Тухай хавсралтад хамаарах төрийн захиргааны	цагдаагийн удирдах албан тушаалтанг дүйцүүлсэн ангилал	Мэргэшүүлэх багц сургалтын агуулга

¹Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйл

	ТОГТООЛЫН ХАВСРАЛТ	УДИРДАХ АЛБАН ТУШААЛ		
1	1 дүгээр хавсралт.	Тэргүүн түшмэл, түүнтэй адилтгах удирдах албан тушаал.	Цагдаагийн ерөнхий газрын дарга.	Төрийн албаны удирдах ажилтны чадвар, стратегийн удирдлага төсөв, санхүүгийн удирдлага, хүний нөөцийн удирдлага, мэдээллийн технологийн бодлого, төрийн албан хаагчийн ёс зүй, төрийн албанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн стандарт.
2	2 дугаар хавсралт.	Эрхэлсэн түшмэл, түүнтэй адилтгах удирдах албан тушаал.	Цагдаагийн албаны дарга.	Төрийн албаны удирдах ур чадвар, бодлогын шинжилгээ, төсөв, санхүүгийн удирдлага, хүний нөөцийн удирдлага, байгууллагын гүйцэтгэлийн удирдлага, захиргааны эрх зүй, мэдээллийн технологийн удирдлага, төрийн албан хаагчийн ёс зүй, төрийн албанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн стандарт.
3	3 дугаар хавсралт.	Ахлах түшмэл, түүнтэй адилтгах удирдах албан тушаал.	Газрын дарга, Хэлтсийн дарга /нутаг дэвсгэр хариуцсан/ Хэлтсийн дарга /Алба/	Бодлого боловсруулах үйл явц, төсөв, санхүүгийн удирдлага, байгууллагын гүйцэтгэлийн удирдлага, захиргааны эрх зүй, мэдээллийн технологийн мэдлэг, төрийн албан хаагчийн ёс зүй, төрийн албанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн стандарт.
4	4 дүгээр хавсралт.	Дэс түшмэл, түүнтэй адилтгах удирдах албан тушаал.	Тасгийн дарга /Алба/ Тасгийн дарга /Аймаг, дүүрэг/	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоолоор дэс түшмэл, түүнтэй адилтгах удирдах ажилтны мэргэшүүлэх багц сургалтын агуулгыг тодорхойлж тусгаагүй.

Монгол Улсын Засгийн газрын 299 дүгээр тогтоолын дагуу Удирдлагын академид зохион байгуулагдаж байгаа “Мэргэшүүлэх багц сургалт”-д цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас жилд дунджаар 6 удирдах ажилтан, “Албан тушаалын ажлын байрны сургалт”-д 15-20 алба хаагч суралцсан нь нэг талаас учир дутагдалтай, нөгөө талаас сургалтын тогтолцоо бүрдээгүй байна.

Дүгнэлт

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага болох цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдах ажилтан, алба хаагчийг бэлтгэх үе шаттай сургах эрхзүйн орчинг боловсронгуй болгох, хууль тогтоомжийг уялдаа, харилцан хамаарлыг судалж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, сургалтын тогтолцоог шинэчлэх шаардлагатай байна.

Санал

1. Монгол Улсын Засгийн газрын 299 дүгээр тогтоолын дагуу Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдах ажилтанд зориулсан “Мэргэшүүлэх багц

сургалт”-ыг Удирдлагын академид зохион байгуулах,

2. Алба хаагчдад зориулсан “Албан тушаалын ажлын байрны сургалт”-ыг Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд зохион байгуулагдаж буй сургалтын кредит цагийг дүйцүүлэн тооцуулах зохицуулалт хийх, эсхүл Дотоод хэргийн их сургуульд зохион байгуулах асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Эх сурвалжийн жагсаалт

-Төрийн албан тухай хууль. УБ., 2017 он

-Цагдаагийн албаны тухай хууль. УБ., 2017 он

-Засгийн газрын 299 дүгээр тогтоол. УБ., 2019 он

-Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын сургалтын нэгдсэн хөтөлбөр төлөвлөгөө. УБ., 2022 он

-Цагдаа, дотоодын цэргийн сургалтын тайлан, мэдээ 2021 он